



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 1/638

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377, 2023 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 312 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай” 02, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам” батлах тухай 03 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 3Г-2/638 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу аймгийн Худалдан авах ажиллагааны газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулж, батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Болд (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга)

Ц.Баасанжав (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)

Х.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)


Нарийн бичгийн дарга: Д.Төмөр (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааны газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг хууль тогтоомжийн дагуу боловсруулж эрх бүхий байгууллагаар хянуулж, батлуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



d/zahiramj

6710011445